



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 175

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах
тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дах заалт, 24 дүгээр зүйлийн 24.2, 24.6, 24.6.7 дах заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2012 оны 129/100 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийг нь төр хариуцах эмийг олгох” журмын 2 дугаар хавсралтын 2.4.9 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дах хэсэг, Эрүүл мэнд, спортын яамны удирдлагын зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрөөс төлбөрийг нь хариуцан олгох дархлаа дарангуйлах эмийн болон Гемодиализийн тусламж, үйлчилгээний үйл ажиллагаа, төсвийн санхүүжилт, түүний зарцуулалтад хяналт-үнэлгээ, дотоодын аудит хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Хяналт-үнэлгээ, дотоодын аудитыг 2015 оны 05 дугаар сарын 04-өөс ажлын 10 хоногт багтаан хийж дуусган, Эрүүл мэнд, спортын яамны Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг Хяналт-Шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Оюунсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Ганчимэг/-д үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080589

Эрүүл мэнд спортын сайдын
2015 оны 05 сарын 09 өдрийн
178 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

**ГЕМОДИАЛИЗИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ, ТӨРӨӨС
ТӨЛБӨРИЙГ НЬ ХАРИУЦАН ОЛГОХ ДАРХЛАА ДАРАНГУЙЛАХ
ЭМИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ҮНЭЛГЭЭ,
ДОТООДЫН АУДИТ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн дарга: Э.Оюунсүрэн, Хяналт-Шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газрын дарга

Нарийн бичгийн дарга: М.Оюунчимэг, Эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээний бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

**Гемодиализийн тусламж, үйлчилгээнд Хяналт-үнэлгээ,
дотоод аудит хийх, ажлын хэсгийн багийн ахлагч:**

Л.Зэндмаа, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны нарийн бичгийн дарга

Гишүүд: Б.Чулуунбат, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын салбарын санхүүгийн хяналт шалгалт асуудал хариуцсан улсын ахлах байцаагч

С.Амарзаяа, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Б.Сансармаа, Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

**Төрөөс төлбөрийг нь хариуцан олгох дархлаа дарангуйлах эмийн зарцуулалтанд
хяналт- үнэлгээ, дотоод аудит хийх, ажлын хэсгийн багийн ахлагч**

М.Уранчимэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Д.Оюунтуяа, Эм, эмнэлгийн хэрэгслийн ханган нийлүүлэлтийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Р.Байгалмаа, Эрүүл мэндийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Г.Туул, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын төсөл, хөтөлбөрийн аудит хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэнд спортын сайдын
2015 оны 05 сарын 04 өдрийн
175 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

**ГЕМОДИАЛИЗИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ, ТӨРӨӨС ТӨЛБӨРИЙГ НЬ
ХАРИУЦАН ОЛГОХ ДАРХЛАА ДАРАНГУЙЛАХ ЭМИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ҮНЭЛГЭЭ, ДОТООДЫН АУДИТ ХИЙХ УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл:

Гемодиализийн эмчилгээ хийлгэх, дархлаа дарангуйлах эмийг хэрэглэх иргэдийн тоо эрс нэмэгдэж, төвлөрөл бий болж, эмчилгээнд хамрагдах иргэдээс тусламж, үйлчилгээний ачаалал, эмч мэргэжилтний зан харилцаа, санхүүжилтийн талаар гомдол ихэссэнтэй холбоотойгоор тус тусламж, үйлчилгээний өнөөгийн байдалд үнэлгээ хийж төвлөрлийг сааруулах арга хэмжээ авах шаардлага тулгараад байна.

Хоёр. Зорилго:

Гемодиализийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах, чирэгдлийг багасгах, тулгамдаж байгаа асуудлыг тодорхой болгож цаашид хүний нөөцийг хангах, иргэдийн аппаратуудын ашиглалтыг сайжруулах, тусламж, үйлчилгээнд хамрагдаж байгаа болон хүлээж байгаа үйлчлүүлэгчийн мэдээлэлийг ил тод болгоход чиглэсэн зохицуулалтыг хангах бодлогын бичиг баримт гаргах үүднээс гемодиализийн тусламж, үйлчилгээний өнөөгийн байдлыг тодорхойлох, Төрөөс төлбөрийг нь хариуцан олгох дархлаа дарангуйлах эмийн зарцуулалтын үйл ажиллагаанд үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгч удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Гемодиализийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдийн судалгаа гаргаж, хүлээгдэж байгаа иргэдийн мэдээлэл гаргах,
- Гемодиализийн тусламж, үйлчилгээг гүйцэтгэж байгаа эмч, мэргэжилтний судалгааг гаргах,
- Гемодиализийн нэг сеанс эмчилгээний бодит өртөг, санхүүжилт, санхүүжилтийн зарцуулалтын тооцоог гаргах,
- Тоног төхөөрөмжийн ашиглалт, өнөөгийн байдал, учирч буй саад бэрхшээлийг тодорхойлох
- Төрөөс төлбөрийг нь хариуцан олгох дархлаа дарангуйлах эмийн хангамж, зарцуулалтыг шалгах

Дөрөв. Хугацаа:


2015 оны 05 дугаар сарын 04-нөөс эхлэн ажлын 10 хоног.

Тав. Хэрэгжүүлэгч:

- Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар
- Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
- Холбогдох мэргэжлийн салбар зөвлөл

Зургаа. Хамрах хүрээ:

- Улсын нэгдүгээр төв эмнэлэг
- Улсын хоёрдугаар төв эмнэлэг
- Улсын гуравдугаар төв эмнэлэг
- Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
- Хавдар судлалын үндэсний төв



Долоо. Үр дүн:

1. Гемодиализийн тусламж, үйлчилгээний өнөөгийн байдлыг тодорхойлох үнэлгээнээс нэгдсэн дүгнэлт гарган танилцуулж, бодлогын бичиг баримт гаргана.
2. Төрөөс төлбөрийг нь хариуцан олгох дархлаа дарангуйлах эмийн зарцуулалтын байдалд хийсэн үнэлгээнээс дүгнэлт, зөвлөмж гаргана.
3. Удирдлагын зөвлөлийн хурлаар танилцуулна.
4. Цаашид дүгнэлтийг үндэслээд авах арга хэмжээ болон шийдвэрүүд гаргана.